



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 55,
Утас: 262449, 266246 Факс: (976-11) 32 52 34
И-мэйл: info@sport.gov.mn

2023.09.19 № 01/757

танай _____ -ны № _____ -т

ГАЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР,
ХОРООДЫН ДАРГА НАРТ

Г Шинэчлэгдсэн уралдааны
Болзол хүргүүлэх тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны А/268 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллага дахь биеийн тамир, спортын үйл ажиллагааны удирдамж"-ийн 3.5 дахь заалтын дагуу "Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага" шалгаруулах уралдааны болзлыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны А/295 дугаар тушаалаар баталсныг хавсралтаар хүргүүлж байна.

Та бүхэн харьяа нутаг дэвсгэрийн өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан хэрэгжүүлэх, шалгаруулалтыг болзолд дурдсан хугацаанд явуулж, холбогдох материалыг ирүүлнэ үү.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

О.БАТТУЛГА





ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар A/295

Улаанбаатар хот

Г Биеийн тамир, спортыг дэмжигч
байгууллага шалгаруулах уралдааны
болзол батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2 дахь заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны А/268 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллага дахь биеийн тамир, спортын үйл ажиллагааны удирдамж"-ийн 3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага" шалгаруулах уралдааны болзлыг хавсралтаар баталсугай.

2.Уралдааны болзлыг улсын хэмжээнд сурталчлах, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагын удирдлагууд, Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтэс (О.Баасан)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны А/318 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

О.БАТТУЛГА



Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 11:00 тоот тушаалын хавсралт

“БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ БОЛЗОЛ

Нэг. Зорилго

Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад зохиогдох биеийн тамир, спортын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хамт олны дунд зохиох арга хэмжээний нэр төрөл, тоог нэмэгдүүлэх, ажилтан, албан хаагчдын бие бялдрын түвшнийг дээшлүүлэх, жил бүр “Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага”-ыг шалгаруулах, сурталчлаад оршино.

Хоёр. Зорилт

Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллагсдын дунд биеийн тамир, спортын үйл ажиллагааг зохион байгуулахдаа Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/268 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллага дахь биеийн тамир, спортын үйл ажиллагааны удирдамж”-ийг хэрэгжүүлэн ажиллана.

Гурав. Зохион байгуулалт, үйл ажиллагаа

Биеийн тамир, спортын салбарын төрийн байгууллага нь засаг захиргааны нэгжийн аймаг, сум, нийслэл, дүүрэг, улсын хэмжээнд, мөн Зэвсэгт хүчин, онцгой байдал, хууль сахиулах салбарын спортын нэгж хороод нь салбарын хэмжээнд “Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага” шалгаруулах уралдааныг жил бүр зарлан шалгаруулалтыг явуулах, урамшуулах, дараагийн шатны уралдаанд оролцох эрх олгох үйл ажиллагааг удирдлагаар ханган зохион байгуулна.

Дөрөв. Биеийн тамир, спортын төрийн байгууллагуудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Биеийн тамир, спортын салбарын төрийн байгууллага нь аймаг, сум, нийслэл, дүүргийн “Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага” шалгаруулах уралдааныг харьяалах нутаг дэвсгэрийн Засаг даргын тамгын газартай зөвшилцэн тухайн онд зарлаж, шалгаруулалтыг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор явуулж, Улсын шалгаруулалтад өрсөлдөх эрхийг аймаг тус бүрээс 1, нийслэлээс 1 байгууллагад олгоно.

4.2. Зэвсэгт хүчин, онцгой байдал, хууль сахиулах салбарын спортын нэгж хороод нь салбар тус бүрд “Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага” шалгаруулах уралдааныг дээд шатны байгууллагатай зөвшилцэн тухайн онд зарлаж, шалгаруулалтыг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор явуулж, Улсын шалгаруулалтад өрсөлдөх эрхийг салбар тус бүрээс 1 байгууллагад олгоно.

4.3. Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо нь аймаг, нийслэл, зэвсэгт хүчин, онцгой байдал, хууль сахиулах салбараас шалгарсан байгууллагуудаас Улсын тэргүүний “Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага”-ыг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор шалгаруулна.

Тав. Шалгаруулалт явуулах

Улсын шалгаруулалтад шалгарсан байгууллагын материалыг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороонд тухайн оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ.

5.1. Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо ажлын хэсэг байгуулан, шалгаруулалтыг явуулна.

5.2. Шалгаруулалтыг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2023 оны А/268 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллага дахь биеийн тамир, спортын үйл ажиллагааны удирдамж"-ийн 2.1, 2.2, 2.3, 3.4 дэх заалтын хэрэгжилтэд 1-10 хүртэлх оноо (хамгийн бага 1, хамгийн их 10) өгч, их онооны системээр байр эзлүүлж, эхний 5-н байгууллагыг шалгаруулан, сурталчилж алдаршуулна.

5.3. Улсын шалгаруулалтад нэр дэвших байгууллагын баримт бичиг бүрдүүлэлт:

- a) Илгээсэн байгууллагын албан бичиг;
- b) Нэр дэвшигч байгууллагын танилцуулга (1-2 хуудас);
- c) Нэр дэвшигч байгууллагын тухайн онд хамаарах биеийн тамир, спортын үйл ажиллагааны тайлан (тоон мэдээлэл, холбогдох материалыг хавсаргах, өмнөх жилүүдэд зохиогдсон үйл ажиллагааг тайлганахгүй);

Зургаа. Шагнал урамшуулал

6.1. Аймаг, сум, нийслэл, дүүрэг, зэвсэгт хүчин, онцгой байдал, хууль сахиулах салбар тус бүрээс "Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага"-аар шалгарсан Байгууллагад олгох батламж, урамшууллыг тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэг, зэвсэгт хүчин, онцгой байдал, хууль сахиулах салбарын Биеийн тамир, спортын газар, хороод хариуцна.

6.2. Улсын тэргүүний "Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага"-аар шалгарсан 5-н байгууллагаад олгох батламж, урамшууллыг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо хариуцна.

6.3. Улсын тэргүүний "Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага"-аар шалгарсан 5-н байгууллага тус бүрд Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны "БАТЛАМЖ", мөнгөн шагнал олгоно.

6.4. Шалгарсан 5 байгууллагад олгох мөнгөн шагналын сан 16,500,000 (арван зургаан сая таван зуун) төгрөг байх бөгөөд дараах хэмжээгээр олгогдоно.

- I байрт шалгарсан 1 байгууллагад 5,000,000 төгрөг;
- II байрт шалгарсан 1 байгууллагад 4,000,000 төгрөг;
- III байрт шалгарсан 1 байгууллагад 3,000,000 төгрөг;
- IV байрт шалгарсан 1 байгууллагад 2,500,000 төгрөг;
- V байрт шалгарсан 1 байгууллагад 2,000,000 төгрөг.

Долоо. Сурталчилгаа

Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага шалгаруулах шат, шатны уралдааныг зарлан зохион байгуулсан байгууллагууд төв, орон нутаг, салбар, улсын хэмжээнд сурталчлах үүрэг хүлээнэ.